



# “САНХҮҮЧ-АУДИТ” ХХК

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ЭРЭЭНЦАВ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд

### Дүгнэлт

Бид 2022 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлого, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бусад хураангуйг багтаасан санхүүгийн тэмдэглэлэс бүрдсэн “ЭРЭЭНЦАВ” ХК (“Компани” гэх)-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар компанийн 2022 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-уудын дагуу үнэн зөв толилуулж байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

### Хараат бус байдал

Нягтлан бодогчдын олон улсын ёс зүйн стандартын зөвлөл (НБОУЁЗСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (МНБЁЗД)-ийн дагуу компаниас хараат бус болно. Бид НБОУЁЗСЗ-ийн болон МНБЁЗД-ийн бусад ёс зүйн үүрэг, хариуцлагыг биелүүлж ажилласан.

### Санхүүгийн тайлангийн талаар Үдирдлагын хүлээх Үүрэг, Хариуцлага

Үдирдлага нь СТОУС-уудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан, эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайллагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

“Санхүүч-Аудит” ХХК,

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо. Нарны зам, Шинэ тэрэг плаза.

Утас/Факс: +976 77116177, 91916177 Е-мэйл: info@sankhuuch-audit.mn



Санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бodoх бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх бүхий этгээдүүд нь Байгууллагын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### **Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага**

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог. Санхүүгийн тайлангийн аудитад хүлээсэн аудиторын үүрэг хариуцлагын талаарх тус компанийн тодорхойлолт нь манай аудиторын тайлангийн нэг хэсэг юм.

“САНХҮҮЧ АУДИТ” ХХК  
ИЛАНГААТАР ХОТ  
Захирал  Б.Алтантуяа  
Хариуц-Аудит ХХК  
УХН11252.5213657  
Монгол Улс, Улаанбаатар хот.  
2023 оны 02-р сарын 14-ний өдөр